

ХҮҮХДИЙН ХЭЛНИЙ АСУУДАЛД

С.Мөөмөө¹

Өсвөр үеийн хэлний системд ойртох, алгуураар бүрэлдэн тогтох явцад онцгой тогтолцоотой хүүхдийн хэл, хэлэхийн асуудал мэдээжээр хэл шинжээчдэд сонирхолтой юм.

Хүүхдийн хэл, хэлэхийн асуудлаар Америк, Европийн олон эрдэмтэн судалсан байна. Эдгээр судалгаань турших, ажиглах аргаар хийгдэхдээ өргөн олон давхарга, ялангуяа, сэтгэлзүйчид, хүүхдийн хүмүүжил, боловсролын мэргэжилтэнд зориулагджээ.

Хүүхдийн хэлэхийн дадал буй болон тогтох дэс дараалалтай явцад хүүхдийн хэлний тогтолцоо бүрэлддэг учраас хэлшинжээчдийн анхаарлыг татдаг ажээ. Ч. Дарвин (1809-1882) Английн байгаль судлаач дарвинизмыг үндэслэгч, амьд ертөнцийн хувьслын үндсэн хүчин зүйлийг нээсэн. Байгалийн шалгарал, удамшил, хувьсалын шинж хэмээх гурван үндсэн хүчин зүйлийг нээсэн, өөрөөр хэлбэл: биологийн үүсч хөгжих, үйл явцыг нээж биологид эргэлт хийсэн гэж үздэг билээ. Чарльз Дарвины хувьслын зарчимд тулгуурласан болох нь нүд чичим ажиглагдана.

Хүүхэд төрснөөсөө эхлэн хоёр янзын дуу чимээг хүрээлэн буй орчин эх, эцгийн сандрах хашгираан, сэтгэл ханамжтай авиаг мэдэрч эхэлнэ.

Эхнийх нь голдуу хэлний урдуурах гийгүүлэгч, хамаршсан авиа, хоёрдох нь хэлний нэлээд хойгуурх хамаршаагүй авиаг хэлдэг нь биологийн шалтгаантай холбоотой. Хүүхэд өсөх тутмаа янз бүрийн авиа, ялангуяа уруулын гийгүүлэгчийг эхний долоо хоногт ялган, барагцаалбал 3, 4 долоо хоногтойдоо шулганахаас хүүхдийн хэлэхэд шилжиж ирнэ.

Судалгаанаас авч үзвэл 1-3, 4-6 настай хүүхдийн хэлийг туршсан байх жишээтэй. Иймд залуу эх, эцгүүд болж өгвөл тэмдэглэл хөтлөх нь зүйтэй.

Хүүхдээ ямар үгээр анхлан хэлд орох, хэдэн настайдаа хөлд орсныг хүртэл бичиж байвал зохилтой.

Европ дахинд мама, нана, папа, баба, дада зэрэг анхны үгээр хэлд ордог юм байна. Нялх хүүхэд насанд хүрэгсдийг ухамсаргүйгээр дуурайж, тодорхойгүй шулганан авиа давтах зэргээр томчуудын хэлсэн үг, авианд алгуур алгуураар ойртож ирдэг байна. Энэ нь ес, арван сартай үеэс эхэлдэг юм байна. Манайхан хүүхэд, түүний хэлэх, хэлний асуудалд тун бүдүүн тойм төдий ханддагийг нуугаад яах билээ.

Далай даян аварга Мөнхбат пизда гэх үгийг их хэлдэг гэнэ. Ач нь орос гуравдугаар сургуульд сурдаг юм байна. Ач хүү нь өвөөгөө дууриагаад пизда гэж сургууль, ангидаа хэлдэг болжээ. Ингээд байхаар нь аваргын ачийн анги удирдсан багш

¹ МУИС-ийн Монгол хэл, соёлын сургууль.

нь ирж уулзана уу гэж урьжээ. Очиход нь танай ач пизда гэж хэлээд байх юм, үүнийг засаж залруулж өгнө үү? хэмээн учирлахад нь Мөнхбат аварга тэр муу пизда тэгж байна уу гээд гэртээ ирээд ачаа зэмлэхдээ “чи муу пизда” ангидаа дандаа пизда гэж ярьдаг юм байна. Муу пизда чи “пизда” гэж хэлэхээ болиорой “пизда” минь гэсэн гэж хүмүүс хошигнон ярихыг би сонссон юм. Магадгүй энэ нь үнэний хувьтай байх. Энэ бол гэр орны томчуудын үг хэллэгийг хүүхэд механикаар ухамсартай, ухамсаргүй авч хэрэглэдгийн нэг жишээ болох мэт.

Зөвлөлтийн нэрт эрдэмтэн Л.С.Выготский хүүхдийн сэтгэхүйг хэлэхтэй нь холбон судалсан юм. Энэ нь улмаар хэл, хэлэх нь сэтгэхүйтэй инстинкт (зөн билэг), рефлекс (хариу үйлдэл), дуурайх зэрэгтэй холбон, ганцаар бодгаль, орчин нийгмийн дотор зохицож хөглөгдөн орох дэс дараалсан шат давхаргыг тунгаан үзжээ.

Дууны биологийн аппарат, сонсол зүйн оньсны үүднээс хүүхдийн хэл, хэлэхийг нарийвчлан судалж эхэлсэн байна. Хүүхдийн шулганахаас хэлэх, хэлд шилжих зүй тогтлыг дэс дараалалтай авч судлах нь зүйтэй юм. Нялх нялзрай үе, хүүхэд саатуулах, цэцэрлэг, бага, дунд сургуулийн хүүхдийн хэл, хэлэхийг зааглан авч судалсан зүйл манайд үгүйлэгдэж байна.

Төрийн шагналт, хөгжмийн зохиолч Бирваа гуай над ярихдаа хүүхэд бүүвэйлэх хүртэл хөдөө, хотын ялгаа гарчихсан байна. Хөдөөний залуу эхчүүд бүүвэйлэхдээ ихээхэн хөг ая намбатай аятай байхад хотод бол заримдаа ямар ч хөг аягүй хүүхдээ зүгээр л бүүвэй, бүүвэй гэж сэгсэрч байх болжээ гэж хошигнон ярьж байсан нь үнэний хувьтай байх гэж бодогдоно. Үүнээс үүдэн зөөлөн хөг аялга, хөгжмийн диез дээшлүүлэх, бемоль доошлуулах өгсөх уруудах аялга гарах биз.

Миний бие 1981 онд орос 5-р цэцэрлэгт 2 хүүгээ оруулсан билээ. 4 настай хүү минь нэг өдөр ахыгаа пидда гэж байна. Маргааш нь ах нь надаас жопа гэж юу гэсэн үг вэ? гэж асууж байв. Бодвол цэцэрлэг дээрээс орос хүүхдийн ярианаас сонссон байх. Үүнээс үзвэл хүрээлэн байгаа орчноосоо хүүхэд шинэ үг сурдаг нь тодорхой байна. Хүүхэд анхныхаа үгсийг хэлж эхлээд л хэлээр харилцдаг болох нь баталгаатай юм. Ингээд л анхны үгээ хэлснээр өөрийн ямар нэг хэрэгцээтэй болох бие махбодтойгоо холбоотой өлсөх, тоглох унтах зэрэг хүслээ илэрхийлэх чармайлт гаргадаг ажээ.

Хүүхэд шулганаж байсан бол дараа нь боловсронгуй болж буй дуудах дадлын үр дүнг хүртэж эхэлнэ. Ингэхлээр эцэг, эх орчин тойрон, цэцэрлэг, сургууль, багш энэ бүхэн хүүхдийн хэл, хэлэх хүмүүжил, боловсрол төгөлдөржихөд чухал нөхцөл болдог ажээ. Улмаар насанд хүрэгсдийн хэлний фонологийн системд ойртож ирдэг. Судалгаагаар амьдралын ойролцоогоор есөн сард хүүхдийн анхны үг бий болдог юм байна. Дээр дурдсан М,Н,В,Р гийгүүлэгч орсон үгс бүх дэлхийн хүүхэд нэгэн адил. Энэ нь дэлхийн биологийн болон нөгөө талаар хүн төрөлхтний сэтгэхүйн нийтлэг үйл ажиллагаатай холбоотой байдагт оршино. Алгуур алгуураар насанд хүрэгсдийн хэлний систем хүүхдийн хэлний сиситем эхэлдэг аж. Энэ бол үгийн сан, хэлзүйн утга, фонологийн системд холбогдож ирдгийг харуулах юм.

Хэрэг дээр хүүхдийн хэл нь насанд хүрэгсдийн хэлнээс цаг ямагт зээлдэж гэмээр үгийн авианы дүр төрх дасаж сурдаг байна. Бид хүүхдийн хэлний тухай ярихдаа нялх нас (0-3), балчир нас (детство), бага нас (отрочество) хүүхдийн хэлний асуудлаар хандаж байна. Финляндын Турку хотын их сургуулийн профессор Жорма Тойвайнен 1-3 настай 25 хүүхдийн хэл яриаг судалж, докторын зэргийг “Inflectional affixes used by finnish 1-3 speaking children aged 1-3 years” сэдвээр 1990 онд хамгаалжээ. Энэ зохиолд

ер нь хүүхэд авиа, фонем хоёрыг ялгах уу, үг, үе хоёрыг ялгах уу, эсвэл салангид авиа, үеийг ялгах уу гэх мэт асуудал дэвшин гарч ирсэн юм.

Уянгын халил

Миний дотно хүн, багш журмын нөхөр, 20-р зууны манлай уран зохиолч, төрийн гурван удаагийн шагналт, ардын уран зохиолч, билгийн чанад хязгаарт хүрсэн, дэлхийн хэмжээний эрдэмтэн гарамгай академич Ц. Дамдинсүрэн гуайгаа эргэн санах нэг зүйл гарч ирэв. Бичиж байгаа сэдэвтэй минь холбоотой юм. Бодоод байх нь монголын уран зохиолтой ч холбоотой зүйл гараад ирэх боллоо. Эхлээд бүүвэйн дуунд эхийн энхрийлэн таалах, хөг аялга нь хүүхдийн хэлтэй аргагүй холбогдоно. Эх хүн нялх нялзрай үрээ бүүвэйлэх нь монголчуудад нийтлэг байдаг. Бид бүүвэйн дууг бага юманд бодоод зүгээр өнгөрч болохгүй юм байна. Энэ нь хүүхдийн хэл, хөгжим дууны хөгтэй давхар уялдаатай болохыг санах хэрэгтэй.

Ц. Дамдинсүрэн гуайн тэмдэглэснээр Д.Нацагдорж “Учиртай гурван толгой” хэмээх алдарт зохиолоо 1934 онд бичсэн бөгөөд уг зохиол “Ган төмөр”, “Гунан хар”, “Шар хад”, “Жийжүү хот”, “Тоорой банди”, “Цэнхэрлэн харагдах”, “Юндэн гөөгөө”, “Төмөр тэрэг”, “Дүйнхэр да лам”, “Гоолингоо” зэрэг монгол ардын дууны аялгуугаар амилж, үзэгчдийн сэтгэлд хоногшиж эхэлжээ. Ардын дууны аяыг “Учиртай гурван толгой” жүжгийн үйл явдалд тохируулан оноож, аялгуутай болгосон гавьяа нь тухайн үеийн найруулагч Д. Намдаг, Гомбожав нар болон театрын жүжигчид, хамт олонд ноогдоно гэж хэлж болно. Тэр цагаас хойш “Учиртай гурван толгой” арав шахам жил тайзнаа тоглогдоод цаашид зөвхөн ардын дуунуудын эвлүүлэг аялгуугаар он цагийг туулахад бэрхшээл учрах болжээ.

1930-аад оны сүүлч, 1940-өөд оны эхэн үеэс Монгол улсад мэргэжлийн гэгдэх өрнө дахины урлаг хүчтэй нэвтэрч эхэлсэн билээ. Тэрхүү мэргэжлийн урлагийн төвшинд дуурь, эсвэл бие даасан аялгуут жүжиг нь зөвхөн үгийн төдийгүй аялгуу эгшгийн хувьд ч цогц шаардлагыг хангасан байх учиртай болов. Энэ шаардлагын улмаас 1940-өөд оны эхнээс “учиртай гурван толгой”-г бие даасан дуурь буюу аялгуут жүжиг болгох гэсэн оролдлого Европын театр, хөгжмийн боловсрол эзэмшсэн найруулагч, хөгжмийн зохиолч, мэргэжилтэн нар монголд, ирж ажиллах цаг үетэй давхцан тохиожээ. “Учиртай гурван толгой”-г дуурь буюу аялгуут жүжиг болгож шинэчлэн зохиох ажилд театрын найруулагч А.Р. Рабинович, хөгжмийн мэргэжилтэн Б.Ф. Смирнов, зураач А. Бельский нар монголын театр, урлаг соёлын зүтгэлтэн нар хамт идэвхийлэн оржээ. Тэдний бодлоор уг зохиолыг дуурь буюу бие даасан аялгуут жүжиг болгоход агуулга, дүрийн харьцаа, зөрчил тэмцлийн хувьд эргэж харах, шинэчлэх, баяжуулах явдал байсан болой. Найруулагч А.Р. Рабинович, өөрийн бодлоо Ц. Дамдинсүрэн нарт мэргэжлийн хүний хувьд хэлж, зөвлөж, санал солилцож байсан байна.

“Музыка композитора Смирнова”, “Главний дирижер” Б. Дамдинсүрэн, текст и стихи Ц. Дамдинсүрэна” нэг үе зохиолч, хөгжмийг Б. Смирнов, Б. Дамдинсүрэн. Дараа нь Б. Смирнов, Ц. Дамдинсүрэн нар 1950-аад оны үеэс хасагджээ. Миний сонссоноор Б. Смирнов баахан гомдож явсан гэдэг. 1956 оны 7-р сарын 7-д Ц. Дамдинсүрэн гуай Монголын зохиолчдын хорооны дарга нарт бичсэн юм. Үүнд: “Д. Нацагдоржийн 1934 онд зохиосон “Учиртай гурван толгой” гэдэг жүжгийн зохиолыг миний бие 1942 онд зассан билээ. Засахдаа гуравны хоёр буюу дөрөвний гуравыг хүртэл шинэчлэн зохиосон юм. Ийм учраас Д. Нацагдорж, Ц. Дамдинсүрэн нарын зохиол гэж арван хэдэн жил бичигдсээр ирсэн. Гэтэл хасаг хэлэн дээр орчуулсан “Учиртай гурван

толгой”-д ганц Д. Нацагдоржийн нэрийг тавьсан ба сүүлийн үеийн сонин сэтгүүлд ганц Нацагдоржийн нэрээр явах болжээ. Анхдугаар зохиосон жинхэнэ эхийг түүний нэрээр явуулах нь зүйтэй юм. Харин гуравны хоёрыг шинэчлэн бичсэн сүүлийн эхээс миний нэрийг хасах нь зохиолдохгүй. Хэрэв энэ засагдсан эхийг муу болсон гэж үзээд, үүнийг тайзан дээр хэрэглэхгүй буюу Нацагдоржийн түүвэрт оруулахгүй байж болох юм. Нас барсан сайн нөхөр Нацагдоржийг би хүндэтгэсээр ирснийг илэрхийлэхийн хамт “Учиртай гурван толгой”-н зохиогчийн тухай дээр үнэн шударга ёсыг баримталж, зохиогчийн эрхийг хамгаалах болов уу гэж Монголын зохиолчдын хороонд найдаж байна” гэжээ. Д. Нацагдоржийн зохиосон “Зохиолын түүвэр” (1955)-ийн оршилд Ц. Дамдинсүрэн, Д. Нацагдоржийн зохиосон “Учиртай гурван толгой”-н анхны эхэд зохиолын төлөвлөгөө өөрчлөгдсөн учраас зөвхөн 230 орчим мөр шүлэг хэвээр ороод бусад 800 шахам мөр шүлэг орхигдсон байна. Ийм учраас “Учиртай гурван толгой”-н хуучин эхийг тайзан дээр тоглоход хэрэглэхгүй боловч уран сайхан шүлгүүдийг уншигчдад танилцуулахын тул энэ түүвэртээ багтаан хэвлэв (5-р тал) гэж бичжээ.

Ц. Дамдинсүрэн гуай засахдаа уг зохиолын гол хоёр баатрын гашуудалтай төгсгөлийг өөрчилж, Балган, Юндэн нарын тэмцлийг ангийн тэмцлийн талаар хурцатгаж, 800-аад мөр шүлгийг шинээр бичжээ. Бидний бодлоор тэр үед Д. Сэнгээ, Ц. Дамдинсүрэн нарын хувийн харьцаа муу байснаас шалтгаалсан байх гэж үзэх үндэслэлтэй. Д. Нацагдоржийн зохиол 894 мөр шүлгээс бүрдсэн бол Ц. Дамдинсүрэн 773 мөр шүлгийг шинээр зохион бичжээ. Театрын тайзан дээр хоёр эхээр нь харьцуулан тоглож үзэх, театрын түүх, архивын материалыг тулган үзэхэд нэлээд тодорхой болно. Нөгөө талаар Цогзолмаа гуай Цогт тайж кинонд тоголохдоо хэдэн настай байсан гэдэг нь тодорхой. Харин Б. Дамдинсүрэн хэдэн настай байсныг тодруулахад тэд нэг үеийн хүмүүс байж магадгүй. Ц. Дамдинсүрэн гуайн мэндэлсний 100 жилийн ойг 2008 онд тэмдэглэсэн билээ.

Анх “Учиртай гурван толгой”-г монгол ардын нэлээд дууны аяар тоглож байсан тухай сонссон юм. Тэгж байтал зохиолч, судлаач Дүгэржавын Баасанжав “Учиртай гурван толгой” хэмээх дуулалт жүжгийн тухай домог, “шинжлэх ухаан амьдрал” сэтгүүлийн 2010 оны нэгдүгээрт бичсэнийг уншаад их Д. Нацагдорж үнэхээр “Үйлийн гурван толгой” нэртэй эхэлж бичсэн нь “Юндэн гөөгөө”-ийн домгоос сэдэвэлсэн болох нь тохирч байгаа юм. Цааш нь ургуулан бодвол, бүүвэйн дуунаас улбаатай байх бололтой. Миний бичиж байгаа хүүхдийн хэл, хэлэхийн асуудалд “Бүүвэйн дуу” холбогдолтой учраас энэ унжруу уянгын гажилт хийсэн болохоо энэ ташрамд тэмдэглэсүгэй.

Миний олж үзсэнээр Америк, Европод турших аргаар эрдэмтэн мэргэд нарийвчлан судалж, олон арван зохиол бичжээ. Тэд 2-4 долоо хоногтой, 4-р долоо хоног, 8-9 сартай мөн 1-3 настай, 4-6 настай хүүхдийн хэл, хэлэхийг судалжээ. Манайд энэ сэдэв бүдэг бадаг, бараг хөндөгдөөгүй байгаа учир нялх, балчир, бага насны хүүхдийн хэл, хэлэхийг орчны тухай эхлэн бичиж, бага, дунд сургуулийн сурагчдын хэлний тухай дурдах хэрэгтэй гэж үзлээ. Хүүхэд том хүний үгээр, дунд үе томчууд хүүхдүүдийн үгээр хэлэх, бичих хандлага газар авсан байна. Ажиглалтаар ихэнх хүүхэд нэг настайдаа хөлд ордог, заримдаа 1-2 настайдаа хөлд орж байна. Тэгээд орчноосоо хэл, хэлэхэдшилждэг аж. Цаашлаад бага, дунд, коллеж, их, дээд сургууь гээд нийгмийн дунд ороод нөгөө сайн, муу айхавтар үгээр ярьдаг юм байна. Миний барагцаалан тоолсноор хүүхэд саатуулах газар, цэцэрлэг, хүүхдийн хүмүүжил, боловсрол, хүүхдийн утга зохиол, уран зохиол, хөгжим, зуслан, нэвтрүүлэг кино, нэвтэрхий толь, сэтгэхүй

гэх мэтээр хүүхдийн төлөө гэх нэр томъёог түүж үзлээ. Мэдээж хүүхдийн театр, хүүхэлдэй байна.

Хүүхэд эхээс эрдэм төгс төрдөггүй. Хүүхдийн хэлийг нялх хүүхэд, ясли, цэцэрлэг, бага, дундад ерөнхий боловсролын сургууль, коллеж, техникум их, дээд сургуулийн оюунтны, сэхээтний хэл, соёл, урлаг, сэтгүүлч, хэвлэл мэдээллийн хэл, их хурлын 76-гийн гэх мэтээр зааглан хэлэлцэж болох юм.

Энэ үеэр “Эх орон телевиз” надаас “Бөөрөнхий хэлтэй хүүхдийн хэлийг зүгшрүүлэх талаар” ярилцлага авахаар хүсэж ирлээ. Би эхлээд “Бөөрөнхий хэлтэй хүүхэд гэж ялгахын оронд, их хурлынхан хүртэл бөөрөнхий хэлтэй болсон бус уу? ” гэж явган шогоор яриагаа эхэлсэн билээ. Монгол улсын хөдөлмөрийн баатар, төрийн соёрхолт, соёлын гавьяат зүтгэлтэн, зохиолч Лодонгийн Түдэвийн бичсэн “Хэлний хүчирхийлэл” хэмээх сонин, сайхан өгүүлэл уншсанаа эргээн саналаа. Уг өгүүллээс эш татъя.

- Харин өвөө нь хөдөөнөөс ирээд, ач хүүтэйгээ ярих гэтэл
- Дээд памперс дай гэж өмнөөс нь шулганаад орон дээр байгаа нэг памбагар юмыг заахад ойлгосонгүй. Юу гэнээ. Юугаа шулганаад байна даа? гэж өвөө нь лавлахад хүргэн хүү нь сонсоод инээж,
- Дээд гэж таныг хэлж байна, паампэрс гэж тэрийг хэлж байна гээд нөгөө памбагар юмыг зааж, “дай” гэж өг гэж байхгүй юу гэсэнд
- Ямар хэлээр ярьж байгаа мөндөл вэ? гэж өвөө нь толгой сэгсэрч лавлахад хүргэн нь –Дээд гэж орсоор “дэд”, Дедушка гэдэг. Памперс гэж энэ л дээ гэж орон дээрээс нэг юм авч өгөхөд өвөө нь
- Үгүй энэ чинь ердөө л живх байна шүү дээ, сайндаа л памбагар живх гэвэл болоо юм бишүү. Дөнгөж хэлд орж байгаа амьтныг монголоор сургахгүй дээ. Орос цэцэрлэгт явдаг юм уу? гэж лавлахад хүргэн нь
- Хүүхэд байтугай томчуул бид нар чинь л үүнийг паампэрс гэж дэлгүүрийхнээс сураадярьдаг болчихлоо гэтэлхон нь нөхөртөө хандаж
- Мээсэж менежерээс ирлээ. Би мээлдэж, маагсий интернетдэж гэнээ. Паап чи паапкаа аваад ир гэх нь тэр.
- Охиныхоо ярианаас юу ч ойлгоогүй тул хүргэнээ
- Авгай чинь ямар хэлээр яриад байнаа? гэж асуув
- Илгээлт ирсэн юм байхаа, богино банзал хямдарч урт нь үнэд орсон бололтой. Тэгээд л намайг хавтастай бичгээ аваад ир гэж байна хэмээн орчуулж өгөв. Охин минь монголоороо л хэлд орсон юмсан, тэгээд одоо өөр хэл сурчихсан юм байх даа гэж бодоод
- Авгай чинь гадаад хэл сурчихаа юу? гэж хүргэнээсээ асуувал
- Ямар ч хэл сураагүй, монголоороо л ярьж байгаа нь энэ. Хотыхны яриа гэж хариулаад гарч одоцгоов.

“Хувцас хунар, хоол унд өөрчлөгдөх нь одоо яая гэх вэ? Хэл яриа нь монгол гэх аргагүй болчихоно гэдэг мөн хачин юм даа” гэж бодлогоширч суутал ач хүү нь

- Дээд, хөөе дээд, чи тийвий нээгээд өг гэж өвөөгийнхөө ханцуйнаас чангаахад
- Ямар юм нээлгэх гээд байнаа энэ мөндөл чинь гэж өвөө нь гайхахад ач хүүгийн эгч нь
- Дээд биш даадий байхгүй гэж дүүгээ зандарснаа
- Бацаан чинь таныг энэ зурагтыг асаагаад өг гэж байна л даа. Дандаа л тэгж байдаг байхгүй юу гэв. Өвөө нь гайхаж, ач хүүгийнхээ хамрыг чимхэж

- Нэгд, би дээд биш өвөө чинь, хоёрт өвөөгөө байтугай энэ эгчийгээ чи гэж дууддаггүй, та гэж хүндлэх ёстой. Гуравт, тийвий гэж энэ хайрцгийг чинь зурагт гэж хөдөөнийхөн хэлдэг юм. Дөрөвт, хаалгыг нээхээс биш энэ зурагтыг нээх аргагүй. Харин залгах юм уу, ажиллуулна гэвэл арай дээр ойлгогдоно, мэдэв үү? За бас чиний эгч чинь ч чамайг бацаан гэнэ үү, нэг хачин нэр хоч өгсөн бололтой. Бас тэгээд байдаг юм бол байхгүй хэрэг үү гэж сургамжилсан чинь зээ охин үг дааж сураагүй бололтой.
- Та өөрөө ч гэсэн миний дүүг мөндөл гэж хочлоод байгаа биз дээ. Мөндөл гэдэг чинь юу юм? гэж хажуугаас асуув.
- Хүүе энэ чинь бас дориун хэрүүлч хүүхэд болох нь уу, мөндөл гэдэг чинь тарваганы бяцхан зулзаганы нэр. Жижигхэн хөөрхөн амьтантай зүйрлэж, өхөөрдөж байгаа юм.
- Пөөх, миний дүүг хулгана гэж байгаа юм уу? Ээжид хэлнэ дээ гээд гарах гэснээ зурагтны товхыг дарчихаад гүйж одов. Том гэгчийн дэлгэцэн дээр нэг том хүн нэг жаалыг магтаж
- Та чинь тогтмол шүдээ угаадаг юмаа? гэж асуух нь сонсдов. Шүдний оо, сойзыг магтаж байгаа бололтой. Хүүхдийг та гэх нь ч хаашаа юм бэ? Бас тогтмол ус гэхээс тогтмол шүд гэмээргүй юм даа. Тогтмол гэхээр бүүр хөдөлдөггүй бат шүд гэж байгаа юм болов уу? Тэгвэл угаах шаардлагатай юм болов уу? Уул нь шүдээ тогтмол эсвэл байнга угаадаг гэж магтаж байгаа юм болов уу? хэмээн өвгөн амандаа бувтнаж сууталбас нэг зар мэдээ зурагтаар гарч, шилтэй ундааг тамшаалсан хүүхэд “аягүй гоё” гэж хэлэх нь сонсдов. “Аягүй” гэдэг нь муухай гэсэн үг баймаар, гэтэл “гоё” гээд байдаг. Улсын төвлөрсөн зурагтын нэвтрүүлгээр арай ингэж яримааргүй юм даа гэж өвгөн мөн л аман дотроо үглэв. Тэгтэл “Монголын Үндэсний олон нийтийн телевиз” гэсэн үг гарч ирэв. Өвгөн бас л гайхлаа. “Монголын үндэсний олон нийт” одоо энэ казакуудыг хэлж байгаа юм болов уу эсвэл халхуудыг хэлж байгаа юм болов уу? Уул нь “Монголын олон нийтийн үндэсний телевиз” гэмээр юм даа гэж өвгөнийг бодож суутал гаднаас том ач хүү нь орж ирээд
- За өвөө хоёулаа гарах уу? Би танд хотыг үзүүлэх даалгавар ааваас авсан. Надад нэг цагийн зав байна гэх нь тэр.

Өвгөн ч ухасхийн босч, хотын байдалтай танилцахаар яарав. Төв гудамжаар өгсөөд, ач хүүтэйгээ хөтлөлцөн яваа хөдөөний тэр өвгөний нүдэнд эрээн мяраанөнгөтэй голдуу гадаадын бичгээр, харь хэлээр дармалдан зурсан, гоё хээнцэр хаягтайгазрууд гудамжны хоёр талаар бие биеийхээ хаяаг даран зайгүй үргэлжилж байлаа. Хааяа нэг монгол нэртэй газар байгаа ч гэсэн “Хаан бууз”, “Хатан бууз”, “Зочин бууз” гэхчилэн, хачин цол хэргэмтэй байх ажээ.

- Энд орж үзэх үү өвөө гэж ач хүү нь нэгэн дэлгүүр бололтой газрыг заахад өвгөн
- Мэдэхгүй, англиар биччихсэн бололтой, юу гэж байгааг мэдэхгүй. Баар бололтой гэж ачийгаа хэлэхэд өвөө
- Тэгвэл орж болохгүй гэв.
- Яагаад?
- Өвгөн толгой сэгсэрч, яагаад гэвэл гадаадын хүний ордог газар биз ээ. Түүнээс биш монгол хүнд зориулсан бол монгол хэлээр хаягласан баймаар даа гэв.

Одоо гол сэдэвтээ шилжье.

Төрийн хошой шагналт, хөгжмийн зохиолч, доктор Н. Жанцанноровын бичсэн “Монгол хөгжмийн эгшиг сэтгэлгээний онолын утга тайлал” номоос эшлэх нь: “Монгол хүн төрж, өндөр сэрүүн газрын эрчимт агаарыг уушиглан” чарласан тэр дуу, түүний анхны “хөгжим”. Энэ нь эцэг эхээ төдийгүй, хорвоо дэлхийг цочоон балмагдуулсан ч баяр хөөр авч ирсэн анхны дуун. Тэр дуун хорвоо, ертөнц, хүний яруу зохицлын нам гүмд бөмбийх эсгий гэрийн дотроос асах их орон зайд тэмүүлж, ер бусын хүчтэйэрчим агуулсан монгол хүний мөнхийн дууны эхлэл. Энэ дуу үрээ төрүүлэх гэж биеэ задартал ёолсон эхийн энэлэнт дууны хариу дуун, эсрэг тэсрэгийн юм шиг атлаа төрүүлэх, төрөхийн заагийг холбосон энэхүү хоёр дууны мөнхийн ивээл, зохицлын яруу ая “хөгжим” нь эхийн бүүвэйн дуу.

Монгол хөгжмийн тухайд дээр тавигдсан энгийн боловч төвөгтэй асуудлуудын хариуг олон ... эхлэл монгол бүүвэйн дуу болж таарна. Бүүвэйн дууны аялга эхийн хувьд үрийнхээ балчир оюуныг эерэг энергитэй эгшгийн холбоосоор бойжуулах нэгэн ёсны эгшиглэгээний “суурь загвар”. Эх бол энэ дуугаар хөгжмийн аялгуу, хэмнэлийн загварыг өөрийнхөө эхээс олж авсан. Анхны эх бүүвэйн дууны аялгууны суурийг тэгвэл ханаас олж авсан байж таарах вэ? Мэдээж малчин амьдралаас. Монгол хүнд тэнгэрийн хүчит дуу, хуй салхины дуу, хотонд гэтэх чононоос үргэх хонин сүргийн түжигнэн ухасхийх нүргээнт дуу, уур хилэн нь бадарсан, орсон буурын шаваа, бухны хүчит бачим урамдалт, айдас хүйдэс, бачимдал төрүүлэх аялгын “хар” талыг илэрхийлдэг бол намрын урихан хонгор салхины чимээ, гол горхины мяралзан бэдэртэх дуун, нуурнаа сэлэх ижил хунгийн ганганаа, хөвчийн ойд цуурай хадах бугын урамдалт, урин цагийн дуудлага болгон хөхөөн дуун баяр баяслынэнгийн холбоо болж, монгол хүний тархи ухаанд шингэж байдаг нь дамжиггүй. Эхээсээ өнчин хоцорсон ботгон буйлаан, үрээ алдсан ингэн тэмээний гунигт гунганаан гэх мэт сэтгэл шимшрүүлэн хайрлаж өрөвдөхийн ид шидийг олсон дуун “гуниглаанууд” эгшиг дууны эерүү зөөлөн холбоосыг шингээж өгдөг нь гарцаагүй. Чухамхүү энэхүү “эерүү зөөлөн” аялгын хуримтлал эхийн бүүвэйн дууны бүтээх, туурвих эх үндэс нь болж таараа.

Монголчуудын дунд хамгийн дэлгэрмэл бүүвэйн дууны үндсэн аялгууг одоо авч үзье гээд бүүвэйн дууны нотод шилжжээ. Бүүвэйн дууны домогт орсон Ягаандарь хуучин Маньбазар гүний хошуу, одоогийн Ховд аймгийн Цэцэг сумын С. Рагчаа гуай хуур хөгжмийнхөө аянд энэ дууг уянгалуулан дуулах нь хэн бүхний сэтгэл зүрхэнд эхийх нь бүүвэйн дуу сонсогдох шиг болдог.

Уг хувилбарын домогт өгүүлэхдээ Юндэн засгийн үед Данзан гэдэг хүн амьдарч байжээ. Тэднийд Должингийн охин Ягаандарь гэдэг үзэсгэлэнтэй хүүхэн зарцлагддаг байсан гэнэ. Тэр хүүхний гоо сайханы магтаал:

Бийр болсон хуруутай
Бичиг болсон ухаантай
Өнгөөрөө гайхуулсан солонго шиг
Өдөөрөө гайхуулсан тогос шиг
Туяагаараа гайхуулсан нар шиг
Тунгалагаараа гайхуулсан толь шиг
Царай зүс нүд дүүрэн

Цараа дүр суудал дүүрэн гоо үзэсгэлэнтэй сайхан хүүхэн байжээ. Гэтэл өөдгүй санаатай Данзан, ядуу зарц Должингийн Ягаандарь хүүхнээр бага хатнаа болгож авах сэтгэл өвөрлөж, хайртай янаг нөхрийг нь харь хол хугацаагүй албанд явуулж, амьдын хагацал зовлонд унагажээ. Хайртай ханиа алдсан Ягаандарь хүүхэн өөдсөн

чинээ өнчин үрээ тэврэн байж, өлгийн дуу аялсныг ухаант мэргэн ард минь уламжилж ирсэн нь энэ гэнэ.

Энэ тэнгэрийн

Өргөн төрсөн үр минь

Бүүвэй бүүвэй бүүвэй

Өөвөн гэрийн

Сөөвөн үр минь

Бүүвэй бүүвэй бүүвэй

Өөжин дотроо

Тайван нойрсдоо үр минь

Бүүвэй бүүвэй бүүвэй

Мөнгөн уруулаа

Цэцэг шиг дэлгэ дээ үр минь

Бүүвэй бүүвэй бүүвэй

Мөөмөн товчоо

Үлгэн хөх дөө үр минь

Бүүвэй бүүвэй бүүвэй

Мөдхөн өсөөд

Төдхөн дэвнэ дээ үр минь

Бүүвэй бүүвэй бүүвэй гэж хүүхдийн нялх балчир үеийг цөөн хэдэн үгээр маш уран яруу эх хүний бүүвэйлэх аялгууг хүний нүдэнд харагдахуйцаар дүрсэлж чадсан байна.

Энэ хэдэн мөрөөс нялх балчир үедээ ийм байдаг шүү дээ гэсэн сэтгэл аргагүй хүнд төрүүлэх нь гарцаагүй. Тэгвэл дараагийн хэсэгт:

Аавын ачааг

Үүрэн зүтгэх үр минь

Бүүвэй бүүвэй бүүвэй

Ачтай ээждээ рашаан амлах үр минь

Бүүвэй бүүвэй бүүвэй

Алтан дэлхийд

Заяа нь дэлгэрэх

Алаг үр минь

Бүүвэй бүүвэй бүүвэй гэж хэдийгээр булбарай байгаа боловч хэт нь том болж аав ээжээ асран хүндэтгэж, өргөн алтан дэлхийд ачтай үр болох юм гэдгийг бэлгэдэж ерөөсөн өнгө харагдаж байна.

Хагд өвсөнд өргөс байдгийг

Гишгэж мэднэ дээ үр минь

Бүүвэй бүүвэй бүүвэй

Халуун хүйтнээр жавар байдгийг

Сөрж мэднэ дээ үр минь

Бүүвэй бүүвэй бүүвэй

Хазаартай морь чинь

Хамхуул өвснөөс бусгаж мэднэ дээ үр минь

Бүүвэй бүүвэй бүүвэй

Харийн газар хар санаатан

Таарч мэднэ дээ үр минь

Бүүвэй бүүвэй бүүвэй гэж ертөнцийн эрээн бараан элдэв юм үзэгдлийг биеэрээ туулан үзэж мэддэг гэдгийг сургамжлан захисан аяс бүхий байна.

Хаттай хэт шиг гантай

Хан бүргэд шиг зоригтой яваарай үр минь

Бүүвэй бүүвэй бүүвэй

Хамбатан дуганд лам болж суувуузай үр минь

Хавчиг үүрсэн бадарчин болж тэнүүзэй үр минь

Бүүвэй бүүвэй бүүвэй хэмээн юуг жигшиж, ямар зүйлийг эрхэмлэн гэрээслэн захиж буй агуулга ил тод харагдаж байна.

Хан хорвоод

Хагацал гэж хэцүү дээ үр минь

Бүүвэй бүүвэй бүүвэй

Хамт байгаад

Салах хэцүү дээ үр минь

Бүүвэй бүүвэй бүүвэй

Хайртай аавгүй

Өнчин үр минь ивий дээ

Бүүвэй бүүвэй бүүвэй

Бороотой дэлхийд

Болж л явбал боллоо үр минь

Бүүвэй бүүвэй бүүвэй

Босоо бие чинь эрүүл явбал

Жаргал тэр шүү дээ үр минь

Бүүвэй бүүвэй бүүвэй

Бодлоо цуглуулж ээж нь унтъя даа

Бондгор үр минь нойрс доо

Бүүвэй бүүвэй бүүвэй гэж хорвоог эргэцүүлэх өөр жаргал хагацлаас хэцүү юм байхгүй гэдгийг маш оновчтой өгүүлсэн байх юм.

SUMMARY

In this article, author discusses about children language from the facts of the Mongolian language.